

**“УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН АНГИЛЛЫГ
ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН 1995 ОНЫ
26 ДУГААР ТОГТООЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 07 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын 1995 оны 26 дугаар тогтоолд нэмэлт оруулах “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь тогтоолын төсөлд Архангай аймгийн Өндөр-Улаан, Жаргалант, Тариат сумдын нутаг дахь “Далтын нуруу, Шаргачны голын ай сав”-ын зарим хэсгийг Байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад хамруулахаар тусгажээ.

Төсөлд дурдсан газар нутгийг Байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авснаар байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, өвөрмөц тогтоц, ховор, нэн ховор амьтан, ургамлын амьдрах орчныг хамгаалах, судалгаа шинжилгээний түшиц газар болгох, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгалийг унаган төрхөөр нь хойч үедээ өвлүүлэн үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзжээ.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсэн, Ж.Батжаргал, Г.Мөнхцэцэг, Ц.Анандбазар нар улсын тусгай хамгаалалттай газар нутагт уламжлалт мал аж ахуй эрхлэхэд тулгардаг асуудал, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулалт, нэр бүхий газар нутгийг тусгай хамгаалалтад хамруулахтай холбоотой судалгаа, шинжилгээний ажил, тусгай хамгаалалтад авсан газар нутгийг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар асуулт асууж, хариулт авч, санал хэлсэн болно.

“Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын 1995 оны 26 дугаар тогтоолд нэмэлт оруулах “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын хурлын эрхэм гишүүд ээ,

“Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын 1995 оны 26 дугаар тогтоолд нэмэлт оруулах “Тогтоолд нэмэлт

оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



Г.МӨНХЦЭЦЭГ